

**БОЛОВСРОЛЫН ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 07 дугаар сарын 05

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дугаар захирамжаар 2023 оныг Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил болгон зарлаж, жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийн талаар удирдлагуудыг мэдээллээр хангахад оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу хийлээ.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЯВЦ

Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилд хийх ажлын төлөвлөгөөг 5 чиглэлийн хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Нийгмийн бодлогын хэлтсээс хагас жилийн байдлаар тооцон гаргаж ирүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ирүүлсэн тайлангаас гадна холбогдох хэлтэс, агентлагаас нэмэлт тодруулга авч 38 арга хэмжээний дундаж үнэлгээгээр тооцон гаргахад 66.1 хувийн хэрэгжилтийн явцтай байна.


Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

№	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь							Дундаж хувь
			100	90	70	50	30	0	ХБ	
1	Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр	7	2						5	100
2	Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр	6	3						3	100
3	Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр	7	1				2	1	3	40
4	Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	7	1	1				3	2	38
5	Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён тээвэрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр	11	3		2	2			4	77.1
6	Дун	38	10	1	2	2	2	4	17	66.1

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хамт хүснэгтээр харуулбал:


№	Үйл ажиллагааны чиглэл	Төсөвлөсөн хөрөнгө /сая төгрөг		Зарцуулсан хөрөнгө /эх үүсвэр тус бүрээр/		
		УТ	ОНТ	УТ	ОНТ	ОУТ, хандив
1	Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр	72	172.5	10.0	7.2	
2	Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр	8.0	86.0		4.0	
3	Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр	225.0	150.0	417.8	1.2	5.0 хандив
4	Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах		30.0		6.2	
5	Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр	44.5	49.1	9.3	2.3	7.3
6	Дун	284.7	487.6	437.1	20.9	12.3

Төсөвлөсөн хөрөнгийн хэмжээг зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулан графикаар харуулбал:



ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Оюунлаг, МУБИС-тай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд багш нарын мэргэжлийн онол, арга зүйг дээшлүүлэх 2 удаагийн сургалт, цахим болон танхимын сорилуудыг зохион байгуулж, 17 судлагдахууны 597 багш нар мэргэжлийн онол арга зүй мэдлэгээ дээшлүүлсэн байна. Мөн 350 сурагч, 10 чиглэлээр 10 удаагийн сорилд хамруулсны үр дүнд Дундговь аймаг ЭЕШ-2023 шалгалтын нийт шалгуулагчид өнгөрсөн жилийн дундаж оноогоо математик 9,1 оноо, монгол хэл 3,3 оноо, нийгмийн ухаан 8,2 оноо, хими 14 оноо, биологи 4,3 оноогоор ахиулж, физик өнгөрсөн жилийн амжилтаа хадгалж, 6 судлагдахуун дундаж оноогоороо улсад 1-10-р эрэмбэлэгдсэн байна.



Залуу багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлж байгаа хичээлийн арга зүйн шинэ санааг эрэлхийлэх, харилцан туршлага солилцох, суралцах, багшийн ур чадвар хөгжлийг дэмжих, шилдэг арга зүй, технологийн сан бүрдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 1-5 жил ажилласан багш нарын дунд “САЙН ХИЧЭЭЛ-2023” арга хэмжээ зохион байгуулав. Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарын 27.8 хувь буюу 138 багш 1-5 жил ажиллаж байгаагаас ур чадварын уралдаанд 100 багш буюу 72.5 хувь нь, цэцэрлэгийн 99 багшийн 22 хувь буюу 22 багш оролцон, хичээл зааж арга зүйгээ харилцан солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсон.



Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан мэргэжлийн багш нарыг урамшуулах журмын төслийг боловсруулан, аймгийн 19 сургуулийн 300 багш, 70 удирдах ажилтнаас гүүглэ форумаар, цахим болон танхимиын уулзалтыг зохион байгуулж төслийг хэлэлцүүллээ. Мөн аймгийн Засаг даргын зөвлөлөөр 2 удаа хэлэлцүүлэн, амжилт үзүүлсэн багш нарын багийг 150,0 сая төгрөгөөр урамшуулахаар баталсан нь багш нарын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлсэн, тэдэнд урам зориг өгсөн, аймгийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажлыг бодиттойгоор дэмжлэг шинэлэг ажил болсон байна.


ЕБС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиад 12 хичээлээр явагдаж, аймгийн 19 сургууль 100 хувь оролцон, нийт 731 хүүхэд оролцон мэдлэг чадвар, оюун ухаанаа сорьсон нь өмнөх үеийнхээс 10 хувиар өссөн сайн үзүүлэлттэй байна. Улсын олимпиадын 3-ын даваанд аймгаас 4 багш, 4 сурагч байр Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс 56 дахь жилдээ зохион байгуулагдаж буй үндэсний хэмжээний шилдэг

илтгэл шалгаруулах "БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ёС ЗҮЙН АСУУДАЛ, ШИЙДЭЛ" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд манай баг тэргүүн байр зэрэг амжилтуудыг үзүүлж, аймгийн Засаг даргын шагнал хүртлээ. Мөн хамгийн их зардал материал шаардагддаг техник технологийн олимпиадад оролцогч багш сурагчдад дэмжлэг 4,0 сая төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасан аргачлалын дагуу 5 чиглэлийн хүрээнд төлөвлөсөн 38 арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу суурь түвшин, зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг харьцуулан хяналт-шинжилгээг хийж дэвшүүлсэн зорилт буюу Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 66.1 хувьтай гэж дүгнэж байна.



Хэрэгжилт 0-30 хувьтай буюу үр дүнгүй хэрэгжсэн арга хэмжээнүүд:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1	Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайд стандартад нийцсэн элсний талбай байгуулах	Элсний талбайтай болсон цэцэрлэгийн тоо	Аймгийн хэмжээнд 22 цэцэрлэгээс эхний хагас жилийн байдлаар 8 цэцэрлэг шинээр гадна тоглоомын талбайд MNS65582015 стандартын шаардлагад нийцсэн элсний талбай болон тагтай элсний хайрцгийг улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, иргэдийн хандив тусламжаар элсний талбай байгуулсан байна.	30
2	Цэцэрлэгийн анги танхимыг хивс болон бусад эрүүл ахуйн шаардлага хангасан дэвсгэр чийг татахгүй дулаан хадгалдаг материалаар сайжруулах	Стандартад нийцсэн дэвсгэртэй болсон анги танхимын тоо	Аймгийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар Сайнцагаан сумын 1,3,8-р цэцэрлэгүүдэд 8 ангийн унтигын өрөө болон урлаг зааланд стандартад нийцсэн дрож, дэвсгэрийг иргэдийн хандив тусламж болон. Тогтвортой хөгжлийн боловсролын төслөөр шийдвэрлүүлсэн байна.	30
3	Цэцэрлэгт анги бүлгүүд сойз ариутгагчтай болох	Ариутгагчийн тоо	Санхүүжилтийн эх үүсвэр байхгүй тул хэрэгжээгүй байгаа	0
4	Төрийн албан хаагчид, иргэдийг монгол бичгийн модуль сургалтад хамруулах	Модуль сургалтын тоо Оролцогчдын тоо	Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлийг хуралдуулан, анхан, ахисан, цахим бичвэрийн модуль сургалтын хөтөлбөрийг батлуулж, 15 сум, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд анхан, ахисан 2 модулийн сургалтыг эхлүүлэх хичээл заах багшийн хуваарийг гарган хүргүүлж, 6 сард балтаан төрийн байгууллагууд сургалтаа зохион байгуулахаар ажиллаж байна. Сайнцагаан суманд 21 төрийн албан хаагчид сургалт явуулсан байна.	0
5	9,12 дугаар анги төгсөгчдөд мод тарих мэдлэг чадвар “Боловсрол төгөл” байгуулах	Тарьсан модны тоо	Сайнцагаан сумын Тамгын газартай яриад газрын асуудал шийдэгдээгүй тул хэрэгжих боломжгүй байна.	0
6	Exsel англи хэлний академи, Оюун ухааны академи, Соробан сампин зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Хамтран ажиллаж байгаа төрийн бус байгууллагын тоо Суралцсан хүүхдийн тоо	Exsel англи хэлний академитай хамтран ерөнхий боловсролын 5 сургуулийн 12-р анги төгсөж байгаа 10 сурагчийг англи хэлний үнэгүй ЭЕШ-д бэлтгэх цахим сургалтад хамруулах ажлыг эхлүүлээд байна.	0

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Төрийн албан хаагчид, иргэдийг монгол бичгийн модуль сургалтад хамруулах ажлыг эрчимжүүлэн сумдын хэлний бодлогын зөвлөл болон агентлагуудад чиглэл өгч ажиллах

Намрын мод тарих өдрөөр 9,12 дугаар анги төгсөгчдөд мод тарих мэдлэг чадвар олгох, “Боловсрол төгөл” байгуулах ажлыг зохион байгуулах

Цэцэрлэгийн анги бүлгүүдийг сойз ариутгагчтай болох


Хэрэгжилт удаашралтай байгаа болон хугацаа болоогүй арга хэмжээнүүдийг эрчимжүүлэн хэрэгжилт үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн сайтад байршуулан иргэдэд мэдээлж сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж байх

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар ажлын хэсгийн хуралд танилцуулан удирдлагуудыг тогтмол мэдээллээр хангах байх

Хэрэгжилтийн тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг тодорхой бичиж нотлох баримтыг хавсаргаж ирүүлэхээс гадна зарцуулсан хөрөнгийн хэмжээг эх үүсвэр тус бүрээр нарийвчлан гаргах

Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн тайлантай хамт тайлагнах

ХЯНАСАН :

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ДААРИЙМАА
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Э.ОДОНЧИМЭГ